

# Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл (JICA/DPUB)

Мэдээллийн эмхэтгэл No.33 (2020.02)

## Дадлагын оюутны тэмдэглэл **Oda Aiyu**

ЖАЙКА дадлагын оюутан (2020.1.6)

Хамтарсан зохицуулах зөвлөлийн 7-р хурал  
(2020.1.10)



**Ода Нацүми**

1-р сарын 6-аас ЖАЙКА-ийн техникийн хамтын ажиллагааны төсөл болох “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл”(DPUB)-д дадлага хийж байгаа Ода Нацүми байна. Би Австралийн Аделаид хотын Флиндерсийн их сургуульд Нийгмийн ажилтны чиглэлээр магистрантуртын 1-р курст суралцаж байна. Аав ээж 2 маань оюуны бэрхшээлтэй хүмүүст зориулсан асрамжийн газарт ажилладаг бөгөөд би өмнө нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн групп хоум (group home)-т ажиллаж байсан туршлагатай. Тус төслийн үйл ажиллагаанд оролцоходоо

1 сарын 10-ны өдөр Хамтарсан зохицуулах зөвлөл (JCC) -ийн 7-р хурал болж, 2019 оны 7~12 сар хүртэлх үйл ажиллагааны тайлан болон 2020 оны 1~5 сар хүртэлх төлөвлөгөөг баталлаа. Хуралд JCC зөвлөлийн гишүүд болох төр, төрийн бус байгууллага мөн ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын төлөөлөл оролцсон бөгөөд холбогдох мэдээллүүдийг солилцов. Хөгжлийн бэрхшээлийн Мэдээллийн лавлах ном болон Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET) зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан тус төсөл нь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэж байгааг хурлын үеэр ойлголоо. Хүний эрх болон нийгмийн шударга ёс нь нийгмийн ажлын үндэс суурь бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ч гэсэн нийгэмд оролцох тэгш эрхтэй. Монгол улс цаашид ч гэсэн илүү тэгш хамруулсан нийгмийг бий болгохын төлөө ирээдүй хойч үе болсон хүүхдүүдийн асуудалд ч анхаарал хандуулах хэрэгтэй гэж би бодож байна.

Япон болон Австрали улсад эзэмшсэн нийгмийн ажилтны эрдэм мэдлэгээ ашиглах болно. Цаашид өөрийн дадлагатай холбоотой үйл ажиллагааны мэдээллийг та бүхэнд цувралаар хүргэх учраас сонирхон уншаарай.



### Хөвсгөл аймаг дахь DET сургалт (2020.01.21)



Монгол улсын баруун хойд хэсэгт орших Хөвсгөл аймагт зохион байгуулагдсан “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт” (DET)-д хамрагдлаа.

DET сургалт нь ялгаварлан гадуурхалт гэх мэт хүний хандлага, ойлголтын саадыг арилгах чиглэлээр явуулж буй DPUB төслийн нэг үйл ажиллагаа юм. DET сургагч багш нар нь зөвхөн өөрсдөө хөгжлийн бэрхшээлийн талаар зааж тайлбарлах бус оролцогчидтой хамт хөгжлийн бэрхшээлийн тухай эргэцүүлэн бодож харилцан ярилцах замаар сургалтаа явуулдаг онцлогтой. Юуны өмнө зураг болон видео бичлэг ашиглан “Хөгжлийн бэрхшээл гэж юу вэ” гэсэн сэдвээр хэлэлцүүлэг хийж, дараа нь Хөвсгөл аймгийг илүү хүртээмжтэй, тэгш хамруулсан аймаг болгохын тулд юу хийх ёстой вэ гэдэг талаар ярилцлаа. DET сургалт нь хөгжлийн бэрхшээлийн асуудал хувь хүнд бус нийгэмд байгаа гэсэн “Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар”-т суурилж явагддаг. Дэд бүтцийн хүчин зүйлүүдээс гадна хүнийг ялгаварлан гадуурхах хандлага нь “Хөгжлийн бэрхшээл”-ийн шалтгаан болж байна. Энэ ойлголтыг хувь хүн бүрт өгч, мөн тодорхой үйлдлүүдийг өөрчлөх шаардлагатай. Ингэснээр бид нийгмийг аажим аажмаар хүн бүхэн амьдрахад таатай, тэгш хүртээмжтэй болгон өөрчилж чадна гэж бодож байна.



Хурлын үеэр

## Алтангадас одтой зүйрлэгддэг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн тухай (2020.1.17)



1-р сарын 17-нд зохион байгуулагдсан “Хөгжлийн бэрхшээлийн салбар дахь олон улсын чиг хандлага” сургалтын үеэр Тэрүя мэргэжилтэн “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц”-ийн

талаар тайлбарласан. Энэхүү конвенцид хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн бэрхшээлгүй иргэний тэгш байдал, тохирох хэрэглэгдэхүүн, ялгаварлан гадуурхалтыг арилгах арга хэмжээ, хүртээмжтэй байдал зэрэг агуулгуудыг тусгасан байдаг. Мөн 1-р сарын 22-нд болсон орон нутаг дахь Салбар зөвлөлийнхөнд зориулсан семинарын үеэр Хигашида мэргэжилтэн “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц”-ийг Алтангадас одтой зүйрлэдэг жишээ бий хэмээн ярьж байлаа. Алтангадас од нь үргэлж нэг байрандаа тодоос тод гэрэлтэж байдаг учраас өөрийн явах замаа олохгүй болсон тохиолдолд тус одоор зүг чигээ баримжаалж, төөрөлгүй явах боломжтой. Цаашид ийм хувирашгүй, хөдлөшгүй алтангадас од мэт “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц”-ийг гол баримтлалаа болгон ажиллах болно.



Семинарын үеэр

## Улс орнуудад хийсэн томилолт болон Хөгжлийн бэрхшээлтэй манлайлагчдаас суралцсан оюуны өмч



Ахлах зөвлөх Чибэ Хисао

Япон сангийн шугамаар санхүүжилт олгосон ажлуудаас сэтгэлд үлдсэн бас нэг ажил нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн урлагийн наадам байсан юм. Гол үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүжгийн үзүүлбэр байсан бөгөөд Камбож, Лаост урлагийн наадмыг зохион байгуулсан. Харамсалтай нь надад урлагийн мэдрэмж байхгүй тул сайхан зүйлүүдийг нь бүрэн дүүрэн мэдрч чадаагүй. Түүнээс гадна томилолтоор их явдаг байсан нь сайхан байлаа. Санхүүжилт олгосон үйл ажиллагааны явц, дуусах үеийн хяналт шалгалт, шинэ үйл ажиллагааны төлөвлөгөө, олон улсын хуралд оролцох зэргээр Тайланд, Камбож, Лаос, Монгол, Вьетнам, Индонез гэх мэт Азийн орнуудаас гадна Судан руу ч явж байсан. Улс орон болгон өөр өөр нөхцөл байдал, тулгамдаж буй асуудалтай байсан бөгөөд би хөгжлийн бэрхшээлтэй олон манлайлагчидтай уулзаж байв. Эдгээр туршлага, сурсан зүйлс маань одоо ч миний оюуны өмч болсоор байна.

### DPUB連絡先

**Office:** Government Building – 2, United Nation’s Street – 5, Ministry of Labor and Social Protection Ulaanbaatar – 15160, Mongolia

**Facebook:** <https://www.facebook.com/jicadpub>

**FACEBOOK**ページに「いいね」をお願いします。

**Website:** <https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html>